



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.06.20 № СГ-112-12/4000
танай _____ -ны № _____ -т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Ган бөмбөлөг Ф125” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240402068 дугаартай тендерт оролцохыг сонирхогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим (tender.gov.mn) системээр дамжуулан ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт /.. хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407015769

**ЭҮТӨҮГ/20240402068 ДУГААРТАЙ ГАН БӨӨРӨНЦӨГ Ф 125 ТЕНДЕРТ ИРСЭН
ДАРААХ ТОДРУУЛГЫН ХАРИУ**

Тодруулгын дугаар: ЭҮТӨҮГ/20240402068/01/03

Тодруулгын огноо: 2024-06-12

Тодруулга:

Сайн байна уу,

ТШЗ 1.3 заалтад Багц-6 Үйлдвэрлэгч гэдгийг нотлоход дараах бичгүүдийг ирүүлнэ.

Үүнд:

-Эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ

-Аж ахуй нэгж эрхлэгчийн гэрчилгээ

Дээрх 2 гэрчилгээнд ямар бичиг баримт орох талаар тодруулга өгч тусална уу. Баярлалаа.

Харцу:

ТШЗ 1.3 заалтад Багц-6 Үйлдвэрлэгч гэдгийг нотлоход дараах бичгүүдийг ирүүлнэ.

Үүнд:

-“Эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ” гэдэгт тухайн үйлдвэрлэгч нь санал болгож буй бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг гэдгийг нотлох бүх төрлийн баримт бичиг байж болно. Үүнд: үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах баримт бичиг бол тухайн баримт бичиг эсхүл эрх бүхий байгууллагаас олгосон үйлдвэрлэгч гэдгийг нотолсон гэрчилгээний хуулбар, мэдэгдэл, албан бичиг, тодорхойлолт гэх мэт баримт бичгийн аль нэг байж болно.

-“Аж ахуй нэгж эрхлэгчийн гэрчилгээ” гэдэгт тухайн улсын улсын бүртгэлийн байгууллага, эсхүл эрх бүхий байгууллагаас олгосон хуулийн этгээд гэдгийг нотлох баримтыг тооцно.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА



М.ОТГОН

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ



Б.ТҮШИГ